

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 01 сарын 13-ны өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

Банк бус санхүүгийн хөрөнгө оруулалт,
санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх
үйлчилгээний журам”-ыг батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Банк бус санхүүгийн хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан журмын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-г тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

БАНК БУС САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛ, САНХҮҮГИЙН
ЧИГЛЭЛЭЭР ЗӨВЛӨГӨӨ, МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэ журмын зорилго нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээ /цаашид “үйлчилгээ” гэх/-ний нэр төрөл, энэхүү үйлчилгээнд оролцогчдын эрх, үүргийг тодорхойлох, зохицуулах, хяналт тавихад оршино.

1.2. Үйлчилгээ эрхлэгч нь энэхүү үйлчилгээнд холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас батлагдсан журам, зааврыг мөрдлөг болгоно.

1.3. Үйлчилгээ эрхлэгч нь үйлчлүүлэгчийн эрх ашиг, хүсэл сонирхолд нийцүүлж, зах зээлийн үнэ, үнийн өсөлт, эдийн засгийн үр ашигтай хугацаа, бодлого зэргийг зөв тооцож, бодит мэдээлэл цуглуулж, төлбөртэйгээр зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээ үзүүлнэ.

ХОЁР. БАРИМТЛАХ ЗАРЧИМ

- 2.1. Үйлчлүүлэгчээс авсан мэдээллийн нууц байдлыг хадгалахад;
- 2.2. Үйлчлүүлэгчтэй хамтран ажиллах хугацаандаа бие биедээ харилцан итгэлцэх;
- 2.3. Амжилттай үр дүнд хүрнэ гэдэгт итгэлгүй байгаа бол төслөөс татгалзах;
- 2.4. Гагцхүү хууль тогтоомжийн хүрээнд зөвлөгөө, мэдээлэл өгөх;
- 2.5. Үүсч болзошгүй эрсдэлийн талаар үйлчлүүлэгчид үнэн бодитоор шуурхай мэдээлэх.

ГУРАВ. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ

3.1. Банк бус санхүүгийн хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээнд дор дурдсан үйлчилгээний төрлүүд хамаарна.

3.2. Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээнд:

3.2.1. гадаадын болон дотоодын зах зээлийн судалгаа, шинжилгээ хийх;

3.2.2. хөрөнгө оруулалтын төсөл боловсруулах, зөвлөгөө, мэдээлэл өгөх;

3.2.3. хөрөнгө оруулалтын төсөлд судалгаа, шинжилгээ хийж, дүгнэлт өгөх;

3.2.4. тодорхой салбар, үйл ажиллагааны чиглэлээр төсөл хэрэгжүүлэх, холбогдох баримт бичиг боловсруулах зөвлөгөө, мэдээлэл өгөх;

3.2.5. хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах, гэрээний төслийг боловсруулах зөвлөгөө, мэдээлэл өгөх;

3.2.6. Монгол улсад гадаадын хөрөнгө оруулалттай компани байгуулах, төлөөлөгчийн газар, салбар, нэгж нээх, холбогдох баримт бичиг боловсруулах зөвлөгөө, мэдээлэл өгөх;

3.2.7. гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд зуучлах;

3.2.8. санхүүгийн болон бизнесийн төсөл, төлөвлөгөө боловсруулах зөвлөгөө, мэдээлэл өгөх;

3.2.9. компанийн бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний маркетингийн төлөвлөгөөг боловсруулах зөвлөгөө, мэдээлэл өгөх.

3.3 Санхүүгийн зөвлөх үйлчилгээнд:

3.3.1. татвар болон санхүүгийн тайлан тэнцэл гаргах, зөвлөгөө, мэдээлэл өгөх;

3.3.2. хуулийн этгээдийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх;

3.3.3. нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах зөвлөгөө, мэдээлэл өгөх;

3.3.4. татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн төлөлт, ногдуулалтын талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх;

3.3.5. тодорхой төслийн шаардлагад нийцүүлэн баримт бичгийг бүрдүүлэх, боловсруулах зөвлөгөө өгөх;

3.3.6. зээл авахад тавигдах шаардлагын дагуу баримт бичиг бүрдүүлэх, зээл олгох үе шатуудын талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх;

3.3.7. эрсдэлийн шинжилгээ, зах зээлийн судалгаа шинжилгээ хийх, зөвлөгөө, мэдээлэл өгөх;

3.3.8. даатгалын зах зээлийн талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх;

3.3.9. хөрөнгийн зах зээлийн талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх;

3.3.10. санхүүгийн удирдлагын чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх.

ДӨРӨВ. ТАВИГДАХ ШААРДЛАГА

4.1. Тус үйлчилгээнд Хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-д заасан шаардлагаас гадна боловсон хүчин нь банк, санхүү, эдийн засгийн болон хуулийн мэргэжилтэй, туршлагатай байх шаардлага тавигдана.

4.2. Тус үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэх баримт бичигт Хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохицуулалтын журам”-д заасан шаардлагаас гадна дараах нэмэлт баримт бичгийг шаардана:

- 4.2.1. хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний журам;
 - 4.2.2. үйлчилгээнд баримтлах ёс зүйн дүрэм;
 - 4.2.3. боловсон хүчний болон гэрээт ажилтны тодорхойлолт, мэргэжлийн диплом, сертификат, үнэмлэхний нотариатаар баталгаажуулсан хуулбар;
 - 4.2.4. үйлчилгээний гэрээний загвар төсөл.
- 4.3. Үйлчилгээ эрхлэгч болон үйлчлүүлэгч талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээг байгуулна. Гэрээнд дараах зүйлсийг заавал тусгасан байна:
- 4.3.1. үйлчлүүлэгч нь иргэн бол түүний овог нэр, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, хаяг, утас, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний болон регистрийн дугаар, хаяг, утас;
 - 4.3.2. гэрээний хугацаа;
 - 4.3.3. үйлчилгээний төрөл, чиглэл;
 - 4.3.4. талуудын эрх, үүрэг, хүлээх хариуцлага;
 - 4.3.5. төлбөрийн нөхцөл;
 - 4.3.6. мэдээллийн нууцлалын хүрээ;
 - 4.3.7. гэрээ хүчин төгөлдөр болох, цуцлах үндэслэл;
 - 4.3.8. бусад.
- 4.4. Үйлчилгээ эрхлэгч нь үйлчлүүлэгч бүрт хувийн хэрэг нээж хөтлөх бөгөөд түүнд гэрээ, төлбөр тооцооны баримт, ашигласан мэдээлэл, тоон үзүүлэлтийн үнэн бодит эсэхийг нотлох эх сурвалжийн жагсаалт болон үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан боловсруулсан баримт бичгийг хавсаргана.

ТАВ. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 5.1. Үйлчлүүлэгч нь дараах эрх, үүрэгтэй:
- 5.1.1. үйлчилгээ эрхлэгчийн санхүүгийн болон ерөнхий мэдээлэлтэй танилцах;
 - 5.1.2. боловсон хүчний мэргэшсэн байдалтай танилцах;
 - 5.1.3. гэрээнд заасан хугацаанд үйлчилгээг бүрэн авах;
 - 5.1.4. үйлчилгээний талаар гомдол санал гаргах;
 - 5.1.5. гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, цуцлах тухай санал гаргах;

- 5.1.6. үйлчилгээ эрхлэгчийн шууд буруутай үйл ажиллагаанаас учирсан хохирлыг нэхэмжлэх;
- 5.1.7. үйлчилгээтэй холбоотой аливаа маргааныг холбогдох хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэх;
- 5.1.8. шаардлагатай гэж үзсэн мэдээллийг үйлчилгээ эрхлэгчид үнэн зөв гаргаж өгөх;
- 5.1.9. хууль тогтоомжоор заасан бусад эрх, үүрэг;

ЗУРГАА. ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ББСБ-ЫН ЭРХ, ҮҮРЭГ

6.1. Үйлчилгээ эрхлэгч нь дараах эрх, үүрэгтэй:

- 6.1.1. үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор үйлчлүүлэгчийн зөвшөөрлийг үндэслэн гуравдагч этгээдийг оролцуулах;
- 6.1.2. үйлчилгээ үзүүлэхтэй холбогдох баримт бичгийг үйлчлүүлэгчээс шаардах;
- 6.1.3. аливаа маргааны талаар шүүхэд нэхэмжлэл гаргах;
- 6.1.4. үйлчлүүлэгчтэй гэрээ байгуулж ажиллах;
- 6.1.5. гэрээгээр хүлээсэн үйлчилгээг заасан хугацаанд бүрэн үзүүлэх;
- 6.1.6. үйлчилгээг үзүүлэхдээ үнэн бодит мэдээллээр хангах зарчмыг баримтлах;
- 6.1.7. үйлчилгээ үзүүлсэн талаар тодорхой, үнэн зөв бүртгэл хөтлөх;
- 6.1.8. үйлчлүүлэгчийн нууцыг чандлан хадгалах;
- 4.1.9. хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

ДОЛОО. ҮЙЛЧИЛГЭЭНД ХОРИГЛОХ ЗҮЙЛ

7.1. Үйлчилгээ эрхлэгчид дараах зүйлсийг хориглоно:

- 7.1.1. энэхүү журмын 3 дугаар зүйлд зааснаас бусад чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх;
- 7.1.2. үйлчлүүлэгчийг хуурамч, буруу, дутуу мэдээллээр хангах, төөрөгдүүлэх;
- 7.1.3. өөрийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн мэдээллийг нуун дарагдуулах, гуйвуулах;
- 7.1.4. үйлчлүүлэгчийн нууцад хамаарагдах мэдээллийг бусдад задруулах, тараах;
- 7.1.5. гэрээнд заасан үйлчилгээнд үл хамаарах мэдээллийг үйлчлүүлэгчээс шаардах;
- 7.1.6. хууль тогтоомжид нийцээгүй бусад.

НАЙМ. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

8.1. Хороо энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах бөгөөд зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО